

保密协议
Нууцлалын гэрээ

甲方: MoEnCo LLC

地址: 乌兰巴托市, 苏赫巴托区第4小区, 首尔街道-23.

邮编: 14250.

法定代表人/负责人:

电话: 976-7711-0567

传真: 976-7711-0570.

А тал: МоЭнКо ХХК

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 4-р хороо, Сөүлийн гудамж -23, Түшиг төв, 3 давхар

Шуудангийн хаяг: 14250

Хууль ёсны төлөөлөлгч

Утас: 976-7711-0567

факс: 976-7711-0570

乙方: 唐山神州机械集团有限公司

地址: 唐山裕彤南区桥北路3号地角

邮编: 063000

法定代表人: 李旭丹

电话: 0315-2960904

传真:

Б тал: Tangshan Shenzhou Machinery Group Co. Ltd.

ХХК

Хаяг: Таньшань Чжоушэнь Луань дүүргийн Яоду тоосгон Сангийн Урс.

Шуудангийн хаяг: 063000

Хууль ёсны төлөөлөлгч

Утас: 0315-2960904

факс:

甲方为香港之上市公司蒙古能源有限公司(股票代码 0276)旗下的蒙古国全资子公司, 拥有的胡硕图矿区位于蒙古国西部科布多省, 拟在胡硕图矿区筹建一个新的干选厂项目(以下称为“新干选项目”), 规模为每年入选毛煤 500 万吨。

Нэг талаас /А тал/ Хонконгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Монголия Энержи Корпорэйшн Лимитэд компанийн /хувицааны код 0276 /100 хувийн хөрөнгө оруулалтай, Монгол улсын Ховд аймгийн нутагт орших Хөшөөт уурхайг эзэмшдэг Монгол дахь охин компани нь Хөшөөтий уурхайд 5 сая тонн түүхий нүүрс баяжуулах хүчин чадалтай шинэ хуурай баяжуулах үйлдвэр/цаашид Шинэ Хуурай Баяжуулах Үйлдвэр /байгуулахар төлөвлөж байна.

乙方为: ...唐山神州机械集团有限公司 (联合体牵头人)

乙方有兴趣与甲方就新干选项目进行磋商、沟通, 并将获得新干选项目有关资料(包括但不限于招标文件)、参与新干选项目投标, 为此乙方将知悉、接触甲方有关保密信息,

mc. Wang

李旭丹

应承担保密义务。经双方友好协商一致，签订本协议。

Нөгөө талаас/ Б тал/ ХХК/ консорциумын удирдагч / нь А талтай түүний хуурай баяжуулах үйлдвэрийн төслийн хүрээнд харилцан санал солилцож, уламаар хуурай баяжуулах үйлдвэрийн холбогдох материалыг/тендерийн баримт бичгийг багтаасан боловч үүгээр хязгаарлагдахгүй/ авч, төслийн тендерт оролцох тул үүний хүрээнд танилцаж, олж авсан А талын нууцлалын зэрэгтэй мэдээллийн нууцыг хадгалах үүрэг хүлээж, талууд зөвшилцөн тохиролцосны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

第一条：目的

甲乙双方承认并同意：乙方将接触和/或知悉/或获得甲方的保密信息，受制于本协议第三条约定，乙方和/或其关联企业的董事、主管、雇员、顾问（包括但不限于乙方聘请的律师、会计师及其它专业人士）、代理人、联合体成员、分包人统称为“乙方人员”也都可能接触和/或知悉和/或获得保密信息（但该等相关人员须符合协议第三条约定方可接触和/或知悉和/或获得保密信息）。

乙方人员的任何违反本协议的行为，均视为乙方违反本协议的行为。

Нэг. Зорилго

Талууд дараах зүйлийг хүлээн зөвшөөрч байна: Б тал нь энэхүү гэрээний гурав дахь заалтыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр А талын нууц мэдээлэлтэй танилцах/мэдэх/эсвэл олж авах бөгөөд Б тал болон хамаарал бүхий этгээдийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдах, ажилтан, зөвлөх/үүнд Б талын өмгөөлөгч, санхүүгийн зөвлөх болон бусад мэргэжлийн зөвлөхийг багтаах боловч үүгээр хязгаарлахгүй/, агент, консорциумын гишүүн, туслан гүйцэтгэгчийг нийтэд нь “Б талых” гэж үзнэ. Эдгээр нь бүгд А талын нууц мэдээлэлтэй танилцах/мэдэх/эсвэл олж авах магадлалтай.

Б талыхны энэхүү Гэрээг зөрчсөн аливаа үйлдлийг Б тал энэхүү Гэрээг зөрчсөн гэж үзнэ.

第二条：保密信息

2.1 保密信息系指与甲方和/或其关联企(包括甲方之母公司蒙古能源有限公司)业非公开资料信息、新干选项目有关的非公开资料信息，包括但不限于在计算机磁盘、光盘读取器、光盘、硬盘或软件中以数字方式存储、保存或记录的信息，在胶片、纸张或任何其他载体上记录的信息以及双方口头沟通的信息，具体包括但不限于：

Хоёр. Нууц мэдээлэл

Нууц мэдээлэл гэдэг нь А тал болон/эсвэл/ түүний хамаарал бүхий компаниуд/А талын толгой компани Mongolian Energy Co.,Ltd хамаарна/болон шинэ хуурай баяжуулах үйлдвэрийн төсөлтэй холбоотой компьютерийн диск, диск уншигч, CD диск, хатуу диск эсвэл программ хангамж дээр тоон хэлбэрээр бичигдсэн буюу хадгалагдсан мэдээлэл зэрэг олон нийтэд ил болгоогүй мэдээлэл эсвэл хальс, цаас, бусад зөөвөрлөгч дээр бичигдсэн мэдээлэл, талуудын хооронд амаар дамжуулсан мэдээлэл зэрэг багтахболовч үүгээр хязгаарлахгүй. үүнд:

(1) 蒙古胡硕图矿区的开采计划、开采方案、开采数量、煤炭存货数量与煤炭开采有关的资料、信息；

a. Монгол Улс дахь Хөшөөтийн уурхайн уулын ажлын төлөвлөгөө, олборлотын

төлөвлөлт ба тоо хэмжээ, нүүрсний нөөц, олборлолттой холбоотой материал, мэдээлэл;

(2) 甲方和/或关联企业、蒙古胡硕图矿区供应商信息、客户名单、商业合作伙伴的资料、信息;

б. А тал болон/эсвэл/ хамаарал бүхий аж ахуйн нэгж, Монгол дахь Хөшөөтийн уурхайн ханган нийлүүлэгчийн мэдээлэл, хэрэглэгчийн жагсаалт, бизнесийн түншүүдийн материал, мэдээлэл;

(3) 甲方和/或关联企业、蒙古胡硕图矿区的人事资料、信息; 甲方或蒙古胡硕图矿区的资产情况、开户银行资料、负债情况、经营状况、应收应付款帐情况、资金周转、融资等财务信息资料;

в. А тал болон/эсвэл/ хамаарал бүхий аж ахуйн нэгж, Монгол дахь Хөшөөтийн уурхайн хүний нөөцийн материал, мэдээлэл, Хөрөнгө, өр төлбөр, банкны дансны мэдээлэл, үйл ажиллагааны байдал, дансны авлага ба өглөг, хөрөнгийн эргэлт, санхүүжилт болон санхүүгийн бусад мэдээлэл;

(4) 甲方和/或关联企业、蒙古胡硕图矿区的各类合同、协议;

г. А тал болон/эсвэл/ хамаарал бүхий аж ахуйн нэгж, Монгол дахь Хөшөөтийн уурхайн гэрээ, хэлэлцээрүүд.

(5) 甲方和/或关联企业、蒙古胡硕图矿区之市场销售资料、市场推广计划, 用户需求信息、营销计划、采购资料、定价政策、产销策略或计划、营销方案, 成本毛利分析资料, 经销商或代理商资料, 价格策略, 销售渠道, 销售模式, 报价手册, 用户数据库;

д. А тал болон/эсвэл/ хамаарал бүхий аж ахуйн нэгж, Монгол дахь Хөшөөтийн уурхайн борлуулалтын мэдээлэл, маркетингийн сурталчилгаа, хэрэглэгчийн эрэлтийн мэдээлэл, маркетингийн төлөвлөгөө, худалдан авалтын мэдээлэл, үнийн бодлого, бүтээгдэхүүний борлуулалтын стратеги буюу төлөвлөгөө, маркетингийн төсөл, зардал ба нийт ашгийн хамаарлын шинжилгээний мэдээлэл, агент эсвэл төлөөлөгчийн мэдээлэл, үнийн стратеги, борлуулалтын суваг, борлуулалтын модуль, үнийн санал боловсруулах гарын авлага, хэрэглэгчийн мэдээллийн сан;

(6) 蒙古胡硕图矿区的采矿许可证、矿产资源补偿费、工程图纸、生产台账、储量资料、开采矿种、开采方式、采矿方法、选矿方法、设计(实际)生产能力、年产量、产值、销售收入、储量变化情况、开采回收率(设计、实际)、选矿回收率(设计、实际)、共伴生矿产及尾矿综合利用情况、采矿权出租/抵押、采矿权获得方式、矿山地质环境保护方案、矿山地质环境治理恢复情况、与矿山有关的资产评估报告、矿产资源储量报告、矿产资源储量评审意见书、矿产资源储量评审备案证明、矿产资源开发利用方案、储量动态监测年度报告、矿产资源储量核实报告、地质勘查资料、勘探报告、气候水文土壤河流资料和信息、交通运输资料和信息; 以及与上述文件、资料、信息相关类似的文件、资料、信息; 甲方或蒙古胡硕图焦煤矿所开采煤炭之各项质量指标、技术参数;

е. А тал болон/эсвэл/ хамаарал бүхий аж ахуйн нэгж, Монгол дахь Хөшөөтийн уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл, АМНАТ, инженерийн зураг төсөл, үйлдвэрлэлийн журнал, нөөцийн материал, ашигт малтмалын төрөл, олборлолтын технологи, ашиглалтын систем, боловсруулах технологи, үйлдвэрлэлийн төлөвлөсөн/бодит/ хүчин чадал, жилийн бүтээл, бүтээгдэхүүний өртөг, борлуулалтын орлого, нөөцийн хөдөлгөөн, цэвэр нүүрсний гарц/төлөвлөсөн, бодит/, баяжуулах үйлдвэрийн гарц/төлөвлөсөн, бодит/, дагалдах ашиг малтмал болон хаягдлын ашиглалт, лицензийн түрээс буюу

Mr. Oloy

Олой

барьцаа, лиценз хэрхэн авсан тухай мэдээлэл, геологи байгаль орчны хамгаалалт, нөхөн сэргээлтийн арга хэмжээ, уул уурхайн холбогдох хөрөнгийн үнэлгээний тайлан, нөөцийн тайлан, нөөцийн үнэлгээний дүгнэлт, нөөцийг улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн тодорхойлолт, нөөц ашиглах төсөл, нөөцийн хөдөлгөөний жилийн тайлан, нөөц бүртгэлийн тодотгол тайлан, геологийн судалгааны анхдагч материал болон тайлан, цаг уур, гидрогеологи, хөрс, гол мөрний мэдээ, мэдээлэл, зам харилцааны мэдээлэл багтах бөгөөд мөн дээр дурдсан баримт бичиг, материал, мэдээлэлтэй ижил төстэй баримт бичиг, материал, мэдээлэл жич Монгол дахь Хөшөөтийн уурхайн чанарын үзүүлэлийн мэдээлэл, техникийн параметрийг хамаарна.

(7) 甲方和/或关联企业、蒙古胡硕图矿区所涉及的诉讼、仲裁、行政程序有关的情况;

ё. А тал болон/эсвэл/ хамаарал бүхий аж ахуйн нэгж, Монгол дахь Хөшөөтийн уурхайн шүүхийн маргаан, арбитрын ажиллагаа, захиргааны ажиллагаатай холбоотой нөхцөл байдал;

(8) 其他甲方披露给乙方的与甲方和/或关联企业、胡硕图矿区生产、销售、研发、经营管理有关的信息、资料。

ж. А талаас Б талд ил болгосон А тал болон/эсвэл/ хамаарал бүхий аж ахуйн нэгж, Монгол дахь Хөшөөтийн уурхайн үйлдвэрлэл, борлуулалт, судалгаа, үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл.

2.2 保密信息不包括:

Нууц мэдээлэлд дараах зүйл хамрахгүй:

2.2.1 乙方从甲方获悉时已被公众获知的信息;

Б тал хүлээж авахаас өмнө олон нийт ил болсон А талын мэдээлэл.

2.2.2 乙方合法地从第三方获得的信息 (前提是该第三方向乙方提供信息没有违反其与甲方的契约和/或侵犯甲方的权利);

Б тал гуравдагч этгээдээс хууль ёсны дагуу олж авсан мэдээлэл / Гуравдагч этгээдээс Б талд өгсөн мэдээлэл нь А талтай байгуулсан гэрээгээ зөрчөөгүй ба/эсвэл/ А талын эрхийг зөрчөөгүй байх/

2.2.3 乙方在不使用或不借助其所知悉的保密信息的情况下独立开发的信息;


Б тал А талаас олж авсан нууц мэдээллийг ашиглаагүй, түүнд тулгуурлаагүй бие даан боловсруулсан мэдээлэл;

2.2.4 甲方明确书面同意乙方可予披露的信息。

А тал ил болгохыг бичгээр Б талд зөвшөөрсөн мэдээлэл

2.3 甲方不对其在本协议项下披露的保密信息的准确性或实用性、是否符合特定目的以及做出任何明示的、默示的或其他方式的保证, 除非甲方在其新干选项目的招标文件中作出了相反承诺。

А тал нь энэхүү Гэрээний дагуу задруулсан нууц мэдээллийн үнэн зөв, ашиг тустай эсэх, эсвэл тодорхой зорилгод нийцсэн эсэх талаар ямар нэгэн ил, далд болон бусад баталгаа гаргаагүй бөгөөд А тал шинэ хуурай баяжуулах төслийн тендерийн баримт бичигт эсрэгээр заагаагүй тохиолдолд.



第三条：保密措施

Нууцлалын арга хэмжээ

3.1 乙方同意对所有保密信息进行严格保密。除非本协议中另行允许或甲方明确书面同意，乙方仅能为与甲方进行磋商、投标新干选项目而使用该等保密信息。

Б тал бүх нууц мэдээллийг чандлан хадгалахыг зөвшөөрч, энэхүү Гэрээнд өөрөөр заагаагүй буюу А тал бичгээр зөвшөөрөөгүй бол Б тал ийм нууц мэдээллийг зөвхөн А талтай хэлэлцээ хийх, шинэ хуурай баяжуулах үйлдвэрийн төслийн тендер шарлгаруулалтанд оролцоход ашиглана.

3.2 除非事先取得甲方的书面同意，否则乙方不得出版、使第三方获得或以其他方式向第三方披露任何保密信息。

А талаас урьдчилан бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд Б тал нь аливаа нууц мэдээллийг хэвлэж нийтлэхгүй, гуравдагч этгээдэд мэдээлэл авах боломж олгох, эсвэл өөр аргаар гуравдагч этгээдэд задруулаагүй байх.

3.3 乙方应仅向直接参与磋商、投标新干选项目并为磋商、投标新干选项目之目的而有必要知道保密信息的最低数量的乙方或其关联公司的董事、高管、员工等相关人士披露保密信息。乙方同意应对其接触到保密信息的前述人员附加本协议规定的同等保密义务。


Б тал нь зөвхөн шинэ хуурай баяжуулах төслийн хэлэлцээр, тендерт шууд оролцож буй, эсвэл төслийн хэлэлцээр, тендерийн хүрээнд зайлшгүй мэдэх шаардлагатай Б талын буюу түүний хамаарал бүхий этгээдийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтан зэрэг цөөн тооны хүмүүст нууц мэдээллийг задруулж болно. Б тал нь дээр дурдсан нууц мэдээлэл олж мэдэх эрхтэй ажилтнуудад энэхүү гэрээнд заасан нууцлалын ижил үүрэг хүлээлгэхийг зөвшөөрч байна.

3.4 如果乙方经甲方书面同意为了实现本项目而咨询或委托第三方，乙方在将保密信息在确需获知的范围内披露给第三方之前，应当与该第三方签订与本协议条款类似的保密协议。如甲方要求，乙方应提供第三方签署的保密协议作为证明，并提供第三方获悉的保密信息的记录。

Б тал нь А талын бичгээр өгсөн зөвшөөрлөөр энэ төслийг хэрэгжүүлэх зорилгоор гуравдагч этгээдээс зөвлөгөө авах эсвэл түүнд итгэмжилэл олгох бол Б тал гуравдагч этгээдийн заавал мэдэх шаардлагатай нууц мэдээллийг түүнд өгөхөөс өмнө энэхүү гэрээний нөхцөлтэй төстэй нууцлалын гэрээг гуравдагч этгээдтэй байгуулах ёстой. Хэрэв А тал шаардсан бол Б тал нотлох баримт болгон гуравдагч этгээдийн гарын үсэг зурсан нууцлалын гэрээ, гуравдагч этгээдийн олж мэдсэн нууц мэдээллийн бүртгэлийг гаргаж өгнө.

3.5 如果具有管辖权的法院或政府主管部门根据职权要求乙方披露其收到的保密信息，乙方应事先通知甲方，并经双方充分协商后向法院或政府主管部门争取在最小范围内披露保密信息，最大限度地保护甲方的利益。如果在紧急情况下乙方在进行信息披露前无法通知甲方，则乙方应当在法律允许的范围内在信息披露后，立即通知甲方其披露的详细情况、时间、内容及披露方式。

Харьяаллын дагуу шүүх эсвэл төрийн байгууллага Б талыг хүлээн авсан нууц



мэдээллээ задруулахыг шаардсан бол Б тал А талд урьдчилан мэдэгдэж, хоёр талын бүрэн зөвшилцөсний үндсэн дээр нууц мэдээллийг шүүх эсвэл төрийн байгууллагад хамгийн бага хэмжээгээр задруулахыг эрмэлзэнэ, А талын эрх ашгийг хамгаалахыг зорино. Онцгой нөхцөл байдлын улмаас мэдээллийг задруулахаас өмнө А талд мэдэгдэх боломжгүй бол Б тал хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд мэдээллийг гаргаж өгсөний дараа үйл явц, цаг хугацаа, агуулга, ил болгосон хэлбэрийн талаар А талд нэн даруй мэдэгдэнэ.

3.6 乙方应在接到甲方通知后的 14 天内, 应向甲方退还全部保密信息, 包括副本的全部和部分、含保密信息的任何记录或文件、因应用保密信息而产生的相关信息, 无论以纸张、数字载体或以其他形式存储。如果乙方退还上述保密信息是不可行的, 则乙方应在征得甲方的同意后, 将保密信息全部销毁, 包括从计算机或其他电子系统中将其删除或抹掉。

Б тал нь А талаас мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор цаас, дижитал зөөвөрлөгч эсвэл бусад хэлбэрээр хадгалсан бүх нууц мэдээллийг, үүнд бүхэлд нь болон хэсэгчлэн хуулбарласан хувилбар, нууц мэдээлэл агуулсан аливаа бүртгэл, баримт бичиг, нууц мэдээллийг ашиглан боловсруулсан холбогдох мэдээллийг бүрэн хамруулан А талд буцааж өгнө. Хэрэв Б тал нь дээр дурдсан нууц мэдээллийг буцааж өгөх боломжгүй бол А талын зөвшөөрлийг авсны дараа бүх нууц мэдээллийг устгах бөгөөд үүнд компьютер болон бусад цахим системд байгаа мэдээлэлүүд хамарна.

第四条: 本合同的内容保密

Дөрөв. Энэхүү гэрээний нуцлал

未取得甲方事先书面同意, 乙方不得将本保密协议的内容以任何方式予以披露。

Б тал нь А талаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэхүү нууцлалын гэрээний агуулгыг ямар нэгэн байдлаар задруулахгүй.

第五条: 进一步探讨

Тав. Дараагийн шатны хэлэлцээр


乙方同意: 自本保密协议签订之日起 12 个月内, 如条件合适可与乙方就新干选项目进行进一步探讨及其相关事宜。

Энэхүү нууцлалын гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 12 сарын дотор нөхцөл боломж бүрдэж, Б талтай шинэ хуурай баяжуулах төслийн болон холбогдох асуудлаар дараагийн шатны хэлэлцээр хийхийг Б тал зөвшөөрч байна.

第六条: 衍生、更新、替代、载体

Мэдээллийн үүсмэл хэрэгсэл, шинэ хувилбар, орлуулагч, тээгч

乙方理解并同意: 任何保密信息或保密信息载体的衍生物、更新物或替代物, 以及含有保密信息的载体 (无论是软盘、硬盘、图表、图纸、磁带、光盘、照片、样品或其他任



何介质等)，除非本协议另有约定，同样视为保密信息，并受本协议保护。

Нууц мэдээлэл эсвэл мэдээлэл зөөвөрлөгчийн аливаа үүсмэл хэрэгсэл, шинэ хувилбар эсвэл орлуулагч болон нууц мэдээлэл агуулсан бусад зөөвөрлөгч / Уян диск, хатуу диск, диаграм, зураг, соронзон хальс, CD, гэрэл зураг, дээж эсвэл бусад зөөвөрлөгч гэх мэт / нь энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол түүнийг нууц мэдээлэл гэж үзэж, энэхүү гэрээгээр хамгаална.

第七条：保密期限

Долоо. Нууцлалын хугацаа

乙方的保密义务为永久，除非其已不属于本协议所述的保密信息。

Энэхүү гэрээнд заасан нууц мэдээлэлд хамаархаа больсоноос бусад тохиолдолд Б тал нь нууцлал хадгалах байнгын үүрэг хүлээнэ.

第八条：非许可、非转让

乙方理解并同意：本协议的任何约定，以及甲方依本协议向乙方提供、披露保密信息，均不能视为甲方授予乙方获得商标的许可使用权、版权作品的许可使用权、专利的实施权或向乙方授予对保密信息的任何专用权、知识产权的许可使用，更不能视为转让与保密信息有关的任何知识产权、专有权给乙方。

本协议的签订、生效、履行均不能被视为甲方有义务与乙方达成新干选项目的任何协议。甲方之母公司蒙古能源有限公司为香港之上市公司。乙方及取得甲方保密信息的乙方人员于蒙古能源有限公司于香港作出新干选项目公众公告披露之前，不得买卖蒙古能源有限公司之股份。乙方亦不得于任何时间利用保密信息买卖蒙古能源有限公司之股份。


Энэхүү Гэрээнд заасан аливаа заалт, мөн энэхүү Гэрээнд заасны дагуу А тал Б талд нууц мэдээлэлээ өгөх, задруулах зэрэг нь Б талд барааны тэмдэг ашиглах болон зохиогчийн эрхээр хамгаалагдсан бүтээлийг ашиглах зөвшөөрөл, патент хэрэглэх эрх, эсхүл нууц мэдээлэлийн аливаа онцгой эрх, оюуны өмчийн эрхийг ашиглах тусгай зөвшөөрлийг Б талд олгосон гэж үзэхгүй. Ялангуяа нууц мэдээлэлтэй холбоотой оюуны өмчийн эрх, онцгой эрхийг Б талд шилжүүлсэн гэж үзэхгүй.

Энэхүү Гэрээнд гарын үсэг зурах, хүчин төгөлдөр болгох, хэрэгжүүлэх нь А тал шинэ хуурай баяжуулах төслийн талаар Б талтай ямар нэгэн хэлэлцээр байгуулах үүрэг хүлээсэн гэж үзэж болохгүй. Монголия Энержи Корпорэйшн Хонконгт шинэ хуурай баяжуулах төслийн талаар олон нийтэд зарлахаас өмнө А талын нууц мэдээллийг олж авсан Б тал, түүний ажилтнууд Монголия Энержи Корпорэйшний хувьцааг худалдан авахыг хориглоно. Б тал мөн ямар ч үед нууц мэдээллийг ашиглан Монголия Энержи Корпорэйшний хувьцааг арилжаалахыг хориглоно.

第九条：违约责任

Ес. Гэрээ зөрчсөний хариуцлага

如乙方违反本协议约定的保密义务，按每违反一次，人民币 100,000 元人民币（壹拾万元人民币）的标准向甲方支付违约金。



Б тал энэхүү гэрээнд заасан нууцлалын үүргээ зөрчсөн бол зөрчил тус бүрээр 100,000 юань /нэг зуун мянган юань/-ны хохирлын торгууль А талд төлнө.

第十条：适用法律及管辖及其他

本协议适用中华人民共和国法律，如甲乙双方就本协议发生争议，由位于北京的中国国际经济贸易仲裁委员会依其仲裁规则进行仲裁。

本协议同时以中文、蒙文作成，如二种文字存在矛盾的，以中文内容为准。

本协议一式二份，甲乙双方各执一份。

Энэхүү гэрээг БНХАУ-ын хууль тогтоомжоор зохицуулна. Хэрэв А тал болон Б талуудын хооронд энэхүү гэрээний талаар маргаан үүсвэл Бээжин дэх Хятадын Олон улсын эдийн засаг, худалдааны арбитрын хороо өөрийн арбитрын журмын дагуу хэлэлцүүлнэ.

Энэхүү Гэрээг Хятад, Монгол хоёр хэл дээр бэлдсэн бөгөөд хэрэв хоёр хувилбарын хооронд зөрчил гарвал хятад хэл дээрх хувилбарыг баримтална.

Энэхүү гэрээг хоёр хувь үйлдсэн бөгөөд талууд тус бүр нэг хувийг эзэмшинэ.

第十一条：其他

Арван нэг. Бусад

1. 本协议一式两份，双方各执一份，具有同等法律效力。

Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг эзэмших бөгөөд адилхан хуулийн хүчинтэй.

2. 本协议经双方签字签章后生效。

Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

甲方：
A тал
授权代表：
Итгэмжилэгдсэн төлөөлөгч：
日期：2023年8月31日
Огноо：

乙方：
B тал
授权代表：
Итгэмжилэгдсэн төлөөлөгч：
日期：2023年8月31日
Огноо：